

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20~~25~~²⁶ оны ~~05~~⁰⁶ сарын ~~11~~¹² -ны өдөр

№ ~~10~~¹¹

Улаанбаатар хот

Салбар нэгж татан буулгах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Компанийн дүрмийн холбогдох заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК-ийн дараах салбаруудын үйл ажиллагааг 2026 оны 06 сарын 15-ны өдрөөс эхлэн зогсоож, татан буулгасугай. Үүнд:

- 1.1. Өвөрхангай аймгийн Богд сумын салбар
- 1.2. Өмнөговь аймгийн Цогтцэций сумын салбар
- 1.3. Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын салбар
- 1.4. Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын салбар

2. Салбар татан буугдсантай холбоотойгоор шаардлагатай арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д даалгасугай.

3. Салбар татан буугдсантай холбоотойгоор эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах, улсын бүртгэлээс хасуулах, холбогдох өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг компанийн Бизнес хариуцсан захирал (П.Болорчулуун)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга (Б.Наранбат)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 06 сарын 12-ны өдөр

№ 12

Улаанбаатар хот

Салбар нэгж шинээр байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.25 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.6.9 дэх заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК нь салбарын үйл ажиллагааг дахин зохион байгуулах зорилгоор дараах салбаруудыг шинээр байгуулсугай.

№	Салбарын нэр	Хаяг, байршил
1	Өвөрхангай аймгийн Уянга сумын салбар	Өвөрхангай аймаг, Уянга сум, 8-р баг, Онги Намнансүрэн 1-р гудамж, 16 тоот
2	Төв аймгийн Жаргалант сумын салбар	Төв аймаг, Жаргалант сум, Өгөөмөр, 2-р баг, 12-р гудамж, 3 тоот
3	Булган аймгийн Хутаг-Өндөр сумын салбар	Булган аймаг, Хутаг-Өндөр сум, Хутаг 1-р баг, С.Магсаржав 1-139 тоот

2. Компанийн дүрэмд заасны дагуу салбар нэгжийн удирдлагыг томилохыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д зөвшөөрсүгэй.

3. Салбар нэгжийг шинээр байгуулахтай холбоотойгоор түрээсийн гэрээ байгуулах, эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах, улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг компанийн Бизнес хариуцсан захирал /П.Болорчулуун/-д даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга (Б.Наранбат)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ

